



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: МУБИС, ДУТС

Хөтөлбөрийн нэр: БАГШ, УРЛАГИЙН БОЛОВСРОЛ

Индекс: D011404

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Эрдэнэхүү

Гишүүд: Д.Уранчимэг
Б.Нацагдорж
С.Отгонтуяа

Улаанбаатар хот
2019-06-23

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- БСШУСЯ-Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
- УБДС-Улсын Багшийн Дээд Сургууль
- ДУТС-Дүрслэх Урлаг Технологийн Сургууль
- МУБИС-Монгол Улсын Боловсролын Их Сургууль
- БМИУЗ-Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
- PESTLE-Political, Economic, Social, Technological, Legal and Environmental analysis-Улс төр, Нийгэм, Технологи, Хууль эрх зүй, Хүрээлэн буй орчны үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга.
- PEOs-Program Educational Objectives- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
- PLOs-Program Learning Outcomes- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
- CLOs-Course Learning Outcomes- Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
- ҮДСБ-Үр Дүнд Суурилсан Боловсрол
- ISCED-F-2013-Боловсролын олон улсын стандарт ангиллын боловсрол, сургалтын хөтөлбөр, мэргэшлийн чиглэлийн ангилал
- CDIO-Conceive, Design, Implement, Operate-Сэтгэх, Зохиох, Бүтээх, Хэрэглэх
- ЭЕШ-Элсэлтийн Ерөнхий Шалгалт
- ОУ-Олон Улс
- ЭШ-Эрдэм шинжилгээ
- БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- ӨМӨЗО-Өвөр Монголын Өөртөө Засах Орон
- ОХУ-Оросын Холбооны Улс
- PDCA-Plan, Do, Check, Act-Төлөвлө, Гүйцэтгэ, Шалга, Сайжруул
- ХААИС-Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
- ХУИС-Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
- ЕБС-Ерөнхий Боловсролын Сургууль
- FabLab-Fabrication Laboratory-Үйлдвэрлэлийн лаборатори
- БМДИ-Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт
- ДЗЗ-Дизайн Зураг Зүй
- ДТ-Дизайн Технологи
- ДУ-Дүрслэх Урлаг

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дүрслэх Урлаг Технологийн Сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, урлагийн боловсрол	
Индекс	011404	
Шинжээчид	Н.Эрдэнэхүү /ШУТИС-ийн МХТС-ийн дэд захирал/ Д.Уранчимэг /СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн захирал/ Б.Нацагдорж /Их засаг их сургуулийн багш/ С.Отгонтуяа / Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан/	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал /Ажлын албаны мэргэжилтэн/	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2020. 06/02	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2020. 06/02	Шинжээчийн багийг томилох
	2020.06.02	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2020.06.02	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2020.06.09	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.06.11	Сургууль дээр ажиллах: Сургуулийн орчинтой танилцах Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	2020.06.12	Сургууль дээр ажиллах: Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, Ажил олгогчидтөгсөгчид, багш нар, оюутны төлөөлөлтэй уулзах, Шинжээчийн багийн уулзалт хийх, Урьдчилсан дүгнэлтийг байгууллагад танилцуулах

	2020.06.19	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.06.22	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2020.06.23	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/		<ul style="list-style-type: none"> • БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, • “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага”, Боловсролын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, • Бусад холбогдох дүрэм, журмууд

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1958 онд Улсын Багшийн Дээд Сургууль (УБДС)-д ерөнхий боловсролын сургуулиудад зураг урлал, хөдөлмөрийн хичээл заах мэргэжлийн багш бэлтгэх анги нээж ажиллуулснаар энэхүү хөтөлбөрийн түүх эхэлж, 1962 онд анхны төгсөлтөөр зураг, хөдөлмөрийн багш мэргэжлээр 22 багш бэлтгэгдэн гарчээ.

Түүхэн хөгжлийн явцад тэнхимийн бүтэц зохион байгуулалт хэд хэдэн удаа өөрчлөгдөж, шинэ шинэ чиглэлүүдээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн байна. 2014 оноос Дүрслэх Урлаг Технологийн Сургууль (ДУТС)-д “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийн багцыг бий болгож “Дизайн, зураг зүйн багш” мэргэжлийг Дизайн зураг зүйн тэнхим, “Дизайн, технологийн багш” мэргэжлийг Технологийн тэнхим, “Дүрслэх урлагийн багш” мэргэжлийг Дүрслэх урлагийн тэнхим тус тус хариуцан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөр талаас нь харвал D011404 индекстэй “Багш урлагийн боловсрол” гэсэн нэг хөтөлбөр байгаа боловч уламжлалаа хадгалан тус хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл бүрийг өөр өөр тэнхимүүд хариуцаж байгаа нь онцлогтой. Тийм ч учраас мэргэжил бүрийн онцлогийг харгалзан тус тусдаа өөрийн үнэлгээний тайлан бичиж, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд бэлтгэсэн байна.

5 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг хөтөлбөрт үнэлгээ хийсэн бөгөөд дараах давуу талуудыг онцолж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуульд урлагийн боловсролын чиглэлээр багшаар ажиллах мэргэжилтний эрэлт, хэрэгцээ өндөр байгаа нь хөтөлбөрийн нэр хүндийг өргөж, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.
- 2014 оноос Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС) хөтөлбөрийн шинэчлэл хийж, сургалтад Үр Дүнд Суурилсан Боловсрол (ҮДСБ)-ын онол арга зүйг нэвтрүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх зорилт тавин ажиллаж холбогдох дүрэм, журам, стандартыг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна.
- Дизайн технологийн багш мэргэжилд ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүй нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж, бусад хөтөлбөрт нэвтрүүлэх олон сайн туршлагыг хуримтлуулсан байна.
- Сургалтын орчин, материаллаг бааз, лабораториудыг шинэчлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж, компьютерын график дизайн, дизайн технологийн чиглэлээр олон шинэ лабораторийг сургуулийн болон дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр байгуулсан байна. Тухайлбал, үйлдвэрлэлийн лаборатори буюу “FabLab”-ийг энд дурдаж болно.
- ДУТС нь бие даасан хичээлийн байртай, ихэнх хичээл бага бүлгээр, практик, лаборатори хэлбэрээр зохион байгуулагддаг учраас оюутнуудын онолын мэдлэгийг хэрэглээ болгох, бие даан суралцах орчин бүрдүүлэх боломж олгож байна.
- Монгол хэл дээр сурах бичиг гаргах чиглэлд багш нар санаачилгатай ажиллаж байгаа нь оюутнууд ихэнх хичээлийн материалыг эх хэлээрээ судлах боломж бүрдүүлж байна.
- Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам (БСШУСЯ)-наас бодлогоор дэмжиж, Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ)-нд өндөр оноо авсан элсэгчдэд

тэтгэлэг олгох журам хэрэгжүүлж байгаа нь сайн элсэгчийг татах, улмаар сайн багш бэлтгэх гол үндэс болж байна.

- Профессор багш нарыг эрдэмжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, имфакт фактор бүхий олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх ажлыг бодлогоор дэмжиж байгаагаас гадна сургуулийн багш докторт суралцах тохиолдолд сургалтын төлбөрийг 50% хүртэл хөнгөлөх журам мөрдөж байгаа нь багш нарыг идэвхжүүлэх нэг хөшүүрэг болж байна.
- МУБИС-ийн сургалтын удирдлага, мэдээллийн системийн программ хангамжийг шинээр хөгжүүлэн, сургалтын үйл ажиллагаа, санхүү, цахим сургалтын чиглэлээр үр дүнтэй ашиглаж байна.

Магадлан итгэмжлэлийн 7 шалгуурын дагуу хөтөлбөрт үнэлгээ хийсэн дэлгэрэнгүй тайланг дараах бүлгээс уншиж танилцана уу.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, технологи, эдийн засаг, хүрээлэн буй орчин, улс төрийн чиг хандлага хөтөлбөрийн төлөвлөлтөд хэрхэн нөлөөлөхийг STEEP шинжилгээгээр гаргасан . (ДЗЗ, ДТ мэргэжлүүдэд)
- Ерөнхий боловсролын сургуульд урлагийн боловсролын чиглэлээр багшлах мэргэжилтэн бэлтгэх эрэлт хэрэгцээтэй уялдуулан төгсөгчийн чадамжийг тодорхойлохыг зорьсон.
- БНХАУ-ын Хөх хотын дүрслэх урлаг, дизайны, АНУ-ын Бостоны багшийн их сургуулийн дүрслэх урлагийн багш хөтөлбөртэй тус тус харьцуулсан судалгаа хийсэн.
- Сонирхогч талуудын оролцоог хангах үүднээс Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дизайн технологийн багш нарыг хамруулан 65 хүнээс судалгаа авч хөтөлбөрийн төлөвлөлтөд ашигласан.
- Сургалтын хөтөлбөрийг боловсролын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан “Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн төлөвлөсөн.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн түвшинд сургалтын хөтөлбөрийг хэрхэн төлөвлөх, боловсруулах талаар нэгдсэн арга зүйгээр хангасан, хөтөлбөрийн төлөвлөлтөд үнэлгээ хийж засаж сайжруулсны дараа албан ёсоор батлан мөрдөж ирсэн байна.
- Хөтөлбөрийн төлөвлөлтийг боловсролын чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого, чиглэлүүдтэй уялдуулах талд МУБИС-ийн удирдлагын түвшинд сайн ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Багш урлагийн боловсрол хөтөлбөрийн багц нь дотроо 3 мэргэжилтэй, тус бүрийг 3 өөр тэнхим хариуцдаг учраас хөтөлбөрийн төлөвлөлт нь арга зүй, чанарын хувьд харилцан адилгүй байна.

- Магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу эрэлт хэрэгцээний шинжилгээг бүрэн хийгээгүй, гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөртэй бүх талаас нь харьцуулж бенчмарк судалгаа хийгээгүй байна.

Зөвлөмж:

- Мэргэжил мэргэжлээр бус, Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн түвшинд эрэлт хэрэгцээг тодорхойлох, сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусгах, гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулах судалгаа, шинжилгээг хийж мэргэжил хоорондын уялдаа холбоог хангасан байдлаар хөтөлбөрийн төлөвлөлт хийх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн эрхэм зорилго, ДУТС-ийн эрхэм зорилготой уялдаатайгаар хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.
- МУБИС-ийн хэмжээнд багш мэргэжлээр суралцагчийн чадамжийг тодорхойлж түүнтэй уялдаатайгаар хөтөлбөрөөр суралцахуйн үр дүнг гаргасан.
- Дизайн технологи мэргэжлийн хувьд CDIO стандарт, арга зүйн жишиг суралцахуйн үр дүнтэй уялдуулсан. Мөн, дизайн технологийн багшийн загварыг боловсруулсан.
- Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд хөтөлбөрийн зорилгыг ажил олгогчдын шаарддаг үр чадварууд болон олон улсын чиг хандлагатай уялдуулах судалгаа хийсэн.
- Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд 3 ангиллаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүн 54, хичээлийн суралцахуйн үр дүн 850 байхаар тодорхойлж гаргасан.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Дизайн технологи мэргэжлийн хувьд CDIO стандарт, арга зүйн дагуу суралцахуйн үр дүн, төгсөгчийн загвар, суралцагчийн хүсэл сонирхлыг тодорхойлсон нь онцлог туршлага болно.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлохдоо гадаадын ижил төстэй сургуулиудаас судлах, суралцах, тусгаж, хэрэгжүүлэх талд дутуу анхаарсан.
- Сургуулийн вэб сайт, оюутны гарын авлага зэрэг мэдээллийн хэрэгсэл ашиглан хөтөлбөрийн зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг нийтэд мэдээлэх ажил хийгдээгүй.

Зөвлөмж:

- Багш урлагийн боловсрол хөтөлбөр 3 мэргэжилтэй хэдий ч ерөнхий суурь, багш боловсролын суурь хичээлүүд ижил байгаа учраас энэ онцлогийг харгалзан хөтөлбөрийн зорилтууд, суралцахуйн үр дүнг илүү оновчтой, харилцан уялдаатай байдлаар тодорхойлох.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 2018 оны 12 сарын А/332 тоот тушаалаар шинэчлэн баталсан.
- Сургалтын хөтөлбөрийг 2014 онд мэргэжил бүрээр боловсруулж, 2018 онд шинэчлэн, баталсан.
- Сургалтын хөтөлбөрт сургалтын төлөвлөгөөний хичээл ба суралцахуйн үр дүнгүүд хоорондын хамаарлын матриц, сургалтад ашиглах шинэлэг арга зүй, үнэлгээний талаар тусгасан.
- Хичээлийн хөтөлбөрийг нэгдсэн арга зүйгээр тодорхой загварын дагуу боловсруулж хөтөлбөрт тусгасан.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Дизайн технологи мэргэжлийн хувьд хичээлийн хөтөлбөр (стандарт)-ийг постер хэлбэрээр бэлтгэн багш, оюутанд хичээлийн суралцахуйн үр дүн, сургалтын арга зүй, сургалтын үнэлгээний талын мэдээллийг илүү ойлгомжтой байдлаар хүргэх боломж бүрдүүлсэн нь сайн туршлага болжээ.

Анхаарах асуудал:

- Мэргэжил бүрээр тус тусад нь хөтөлбөр боловсруулахдаа тэдгээрийн хоорондын хамаарал, уялдаа холбоог гаргаагүй, бичиг баримтууд өөр хоорондоо ялгаатай болсон.
- Хөтөлбөрийн төлөвлөлтийн нь нийтлэг стандартын бичиг баримтад хэт баригдмал, хөтөлбөрийн өөрийн онцлогийг бага харгалзсан.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийн бичиг баримтуудыг сайжруулж А/174 тушаалаар батлагдсан шаардлагын дагуу үндсэн бүлгүүдийг илүү тодорхой, дэлгэрэнгүй боловсруулж, хичээлийн хөтөлбөрүүдийг хавсралт байдлаар оруулах.

- Сонирхогч талуудын санал зөвлөмжийг хэрхэн тусгасан талаар хурлын тэмдэглэл гэх мэт нотлох баримтуудыг бүрдүүлдэг болох.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн код, кредит, заагдах улирал, заавал сонгон хэлбэр зэрэг мэдээллийг тодорхой гаргаж сургалтын төлөвлөгөө боловсруулсан.
- Сургалтыг өдрийн хэлбэрээр 4 жилээр зохион байгуулах ба дизайн технологи-126, дүрслэх урлаг-127, дизайн зураг зүй-127 кредит судлахаар төлөвлөгдсөн байна.
- Нийт судлах хичээлийн 20%-аас ихгүй нь ерөнхий суурь, 30%-аас ихгүй нь багш боловсролын суурь, 50%-аас багагүй нь мэргэжлийн хичээл байхаар төлөвлөсөн нь А/174-д заасан шаардлагад нийцэж байна.
- Мэргэжил бүрээр хичээл хоорондын хамаарлыг харуулсан зураглал буюу хөтөлбөрийн модыг боловсруулсан байна.
- Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд өмнө мөрдөж ирсэн сургалтын төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийсэн байна.
- Суралцагчийн цагийн ачаалалд дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгсөн байна.
- Удирдлага мэдээллийн системийн оюутны вэб гэсэн дэд системээр дамжуулан оюутнууд хичээл сонгох, бусад сургалттай холбоотой үйлчилгээ авах боломж бүрдсэн.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Дизайн зураг зүйн багш, дизайн технологийн багш, дүрслэх урлагийн багш мэргэжлүүдийг агуулга, суралцахуйн үр дүн талаас нь харьцуулан ялгааг нарийн тодорхойлоогүй.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд ба хөтөлбөрт байгаа хичээл хоорондын хамаарлын матрицад үндэслэн хичээл хоорондын уялдааг гаргах, нэг хичээлээр олгох чадамжийг зөв төлөвлөх талд ажиллаагүй.

Зөвлөмж:

- Цаашид хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдаатайгаар хичээлийн суралцахуйн үр дүнг зөв төлөвлөх, нэг улиралд, нэг хичээлийн жилд заагдах хичээл хоорондын уялдааг суралцахуйн үр дүн талаас нь гаргаж хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх талд анхаарах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дизайн зураг зүйн мэргэжлийн хувьд шавь төвтэй сургалтын арга зүй, урлангийн сургалтын арга зүй, загварчлалын онол арга зүй, интерактив сургалтын арга зүй, асуудалд суурилсан сургалтын арга зүйг тус тус сургалтад ашиглаж ирсэн байна.
- Дүрслэх урлаг мэргэжлийн хувьд судлан шинжлэх арга зүй, багаар ажиллах, асуудал шийдвэрлэх арга зүй, бүтээлч эрэлхийллийн арга зүйг тус тус голлон ашиглаж байгаа туршлага, үр дүнг баримтаар баталгаажуулсан байна.
- Дизайн технологи мэргэжлийн хувьд багт суурилсан, эвлүүлгийн, тонгоруу анги, дүрд тоглох, харилцан бие биеэсээ суралцах, тохиолдолд суурилсан зэрэг идэвхтэй сургалтын арга, хэлбэрүүдийг голлон ашиглаж ирсэн байна.
- Мөн сургалтын лаборатори, урлангуудад оюутнууд бие даан суралцаж, мэдлэгээ хэрэглэн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлж чадсан байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрт байгаа заавал судлах 6 хичээлээр оюутнууд багш боловсролын онол, арга зүйг эзэмшдэг. Энэ агуулгын хүрээнд хичээл зааж байгаа багш нар олон төрлийн сургалтын арга зүйг ашиглаж байгаа нь онцлог байна.

Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглаж байгаа дээрх арга зүй, хүргэх хэлбэрүүдийн аль нь илүү үр өгөөжтэй, ямар хичээлд аль арга зүй нь тохирч байгаад үнэлэлт дүгнэлт өгөх талд дутуу ажиллажээ.

Зөвлөмж:

- Багш урлагийн боловсрол хөтөлбөр нь багшаар ажиллах мэргэжилтэн бэлтгэдэг учраас суралцахуйн онолд тулгуурлан мэргэжлийн хичээлд ашиглах сургалтын арга зүйг зөв тодорхойлж хэрэгжүүлэх.
- Мэргэжлийн хичээлийг заахад ямар сургалтын арга зүйг хэрхэн ашиглах чадварыг оюутнууддаа эзэмшүүлэхэд багш бүр анхаарах.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Блумын таксономид суурилсан байдлаар хичээлийн шууд үнэлгээг төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, 6 түвшинд чадамжийг тодорхойлон түүнийг үнэлэх арга зүйг хэрэгжүүлж иржээ.
- Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд хичээлийн суралцахуйн үр дүнд үнэлгээ хийх алгоритм боловсруулж хэрэглэж байна. Мөн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг үнэлэхэд рубрикэн үнэлгээг ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Дизайн технологи мэргэжлийн хувьд суралцагчийн чадамжийг үнэлэх асуулт даалгаврын санг Блумын таксономитой уялдаатайгаар боловсруулан гаргасан нь түгээн дэлгэрүүлэх сайн туршлага болжээ.

Анхаарах асуудал:

- Хичээл бүрээр эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлагыг тус бүрээр нь хэрхэн үнэлэх аргазүйг тодорхойлж, багш нар түүнийг хичээлдээ хэрэгжүүлэх талд үр дүн гараагүй байна.

Зөвлөмж:

- Цаашид хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг багш хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүй боловсруулж гарын авлага гаргах, түүнийг багш нарт зааж эзэмшүүлэх, хэрэгжүүлэх шаардлага байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1. Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- 1958 оноос одоог хүртэл ерөнхий боловсролын тухайн чиглэлийн багш нарыг тасралтгүй бэлтгэж ирсэн түүхтэй. 2010-2011 оны хичээлийн жилд ДУТС нь

хичээлийн шинэ байрыг ашиглалтад оруулан сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж суурь баазаа бэхжүүлж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ирсэн. /616 ам метр талбайтай, 6 давхар байр/

- ДУТС нь өөрийн хичээлийн байрнаас гадна МУБИС-ийн нэгдүгээр байрны 209 ам метр талбайг сургалтыг журмаар эзэмшиж байна.
- Сургуулийн барилга хийц материалын хувьд стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, анги танхимын зохион байгуулалт сайтай, агаар сэлгэлт, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг сайтай.
- Харуул хамгаалалтын хувьд тогтмол ажилладаг ээлжийн жижүүртэй. Бүх давхарт болон лекцийн заал, номын сан, оффисын өрөөнүүдэд өндөр хүчин чадалтай хяналтын камер суурилуулсан.
- Давхар бүрд ариун цэврийн өрөө байрладаг ба өрөө бүр эрэгтэй эмэгтэйгээр тусгаарлагдсан, угаалтууртай, устай.
- Бохирын систем, хогийн сав, хогийн цэгийн асуудал бүрэн шийдэгдсэн.
- Зориулалтын анги танхимд сүүлийн үеийн хүчин чадал бүхий проектор, хэвлэгч, дэлгэц, ухаалаг самбарыг суурилуулан сургалтандаа ашигладаг.
- Орчин үеийн ухаалаг удирдлагатай CNC машин, 3D принтер, лазер зүсэгч машинаар тоноглогдсон “FabLab” лаборатори байгуулсан.
- Дотоод сүлжээ, интернетэд холбогдсон сүүлийн үеийн хурд багтаамж сайтай компьютер, принтерээр багш ажилтан, тэнхим бүрэн хангагдсан. Мөн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон “Багшийн хөгжлийн төв”, “Инновац хөгжлийн төв” зэргийг байгуулж байна.
- Номын санг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцсэн үйл ажиллагаатай болгон, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
- Сургуулийн бүхий л орчин шилэн кабелиар холбогдсон WIFI буюу утасгүй 24 цагийн интернэтэд холбогдсон, интернет ашиглах боломж нээлттэй.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын анги танхим, лаборатори, урлангийн дундаж ачаалал өдөрт 6-7 цаг, долоо хоногт 32 цаг байна. Үлдсэн хугацаа нь суралцагчдад нээлтэй байдаг ба оюутнууд бие даан суралцах сургалтын орчинг боломжтой түвшинд шийдсэн байна.
- Мөн орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон анги танхим, лабораториуд, технологийн шийдэл сайтай хурлын танхим, номын сан, фондын хэрэгслийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн зорчих зам зэрэг олон асуудлыг шийдвэрлэсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын анги танхим, лаборатори, урлангийн зай талбай бага учраас нэг оюутанд оногдох талбайн стандартыг хангахгүй байна.

Зөвлөмж:

- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгаа хийж, үр дүнд үндэслэн энэ чиглэлд үйл ажиллагаа зохион байгуулах нь зүйтэй.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангагдсан.
- E контент боловсруулж сургалтын материалын нөөц бүрдүүлэх, түүний чанарыг хянах, сайжруулах асуудлыг МУБИС-ийн хэмжээнд бодлогоор дэмжиж үр дүнтэй ажиллаж байна.
- E-контент буюу цахим хичээлийг сургалтад ашиглах багшийн цахим системийг хөгжүүлэн үр дүнтэй ашиглаж байна.
- Бакалавр, магистрын судалгааны ажил, мэргэжлийн дадлагын тайлангийн санг хэвлэмэл болон цахимаар бий болгон ашиглаж байна.
- Багш нар сургалтандаа хэрэглэний программ болох MS-Office багц программ, цахим хичээл бэлтгэх iSpring suite, Adobe Flash, судалгааны SPSS зэрэг программ хангамжуудыг өргөнөөр ашиглаж байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг хөтөлбөрт оролцогчдод их сургуулийн вэб хуудас, их дээд сургуулиудын боловсролын үзэсгэлэн, нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэргэжил сурталчлах хичээл болон сургалтын үйл ажиллагааны явцад холбогдох нэгжийн мэдээллийн самбар, анги бүлгийн зохион байгуулалтын бүтцээр, хэвлэмэл материал буюу гарын авлага байдлаар түгээж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Зөвлөмж:

- Судалгааны зориулалттай программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн эрэлт хэрэгцээг оновчтой зөв тодорхойлж хангадаг байх, судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгох.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан нь Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн /MNS5742:2007/ стандартын шаардлагыг ханган ажилладаг, тусдаа байртай.
- ДУТС-ийн оюутанд үйлчилдэг уншлагын танхим, 10-15 суудалтай эрдэм шинжилгээ, судалгааны уншлагын танхимаар үйлчилдэг. Мөн гэрээр олгох танхимтай байна.
- Сургуулийн номын сан нь ном сурах бичгийн мэдээллийн санг цахим хэлбэрт оруулж ашиглаж байна. (Нийт 183932 ном сурах бичгийн мэдээллийн санг цахим хэлбэрт оруулсан байна)
- Номын сангийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийг жил бүр тодорхой хүрээнд хийж ирсэн байна. (Номын санд сүүлийн 5 жилд шинээр бүртгэж авсан ном, сурах бичгийн тоо, зарцуулсан үнийн дүнг тайланд тусгасан байна. Шинэ ном, сурах бичигт жилд дунджаар 60-70 сая төгрөг зарцуулж байна, үүнийг цаашид нэмэгдүүлж оюутны төлбөрийн 1%-аас доошгүйг зарцуулахаар журамд тусгаж өгсөн байна)
- Номын сангийн үйлчилгээ, хүртээмжийн нэмэгдүүлэх чиглэлээр өөртөө үйлчлэх орчин үеийн технологи нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.
- Номын фондыг мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүл, гарын авлага, судалгааны материалаар баяжуулахаас гадна, номын ашиглалт, хэрэглээ тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. Мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт, шинэчлэл хийж байна. (Ном сурах бичиг монгол хэлээр-1000 гаруй, гадаад хэл-700, шинээр 12 ном, гарын авлага хэвлүүлсэн байна)
- Номын сангаар үйлчлүүлсэн уншигчийн тоог сүүлийн 5 жилээр харьцуулан авч үзэхэд тогтмол өссөн байна. (Номын сангаар үйлчлүүлэгчийн бүртгэл судалгаа)
- Номын сан нь соронзон мэдрэгчтэй хаалга, 3 үйлдэлт принтер, ном сэлбэн засах (үдэх, наах, зүсэх, өрөмдөж цоолох) иж бүрэн төхөөрөмжтэй.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүдийн үндсэн сурах бичгийн судалгаа, хүртээмжийн талын мэдээллийг хичээл бүрээр гаргаж, нэг оюутанд оногдох ном сурах бичгийн стандарт хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийгээгүй байна.

Зөвлөмж:

- Цаашид, Багш, урлагийн боловсрол хөтөлбөрт хамаарах ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл, судалгааны материалын санд дүн шинжилгээ хийж эрэлт хэрэгцээг тодорхойлон, үндэслэлтэйгээр баяжуулалт хийх.
- Номын сангийн орчин, үйлчилгээг орчин үеийн уншигч оюутнуудын сэтгэл зүйн онцлог, суралцах арга барил, хүсэл сонирхолд нийцүүлэн шинэчлэн сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн “Хөтөлбөрийн хорооны ажиллах журам”-ыг 2014 оны А/221 тоот захирлын тушаалаар баталсан байна.
- МУБИС-ийн хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүн сургууль дээр хөтөлбөрийн салбар хороо, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид хөтөлбөрийн дэд хороо ажилладаг.
- Анхан шатны нэгж болох тэнхимийн багш нар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж тэнхимийн хурлаар хэлэлцэж дараа нь хөтөлбөрийн дэд хороо, салбар хорооны хурлаар хэлэлцэж баталгаажуулдаг байна. Хөтөлбөр боловсруулах бүрэлдэхүүнд хөтөлбөрт оролцогчдын төлөөллийг оруулах, мөн ажил олгогчийн төлөөллийг ажиллуулж санаа бодлыг тусган ажилладаг байна. Оролцогч талуудын зохих нийцлийг хангаж ажиллаж байгаа нь давуу талтай байна.
- ДУТС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, БСШУСЯ-наас батлан гаргасан дээд сургуулийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, тушаал, заавар, стандартыг мөрдөн ажиллаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхан шатны нэгж /тэнхим/ нь богино, дунд, урт хугацаагаар төлөвлөлт хийж ахиц, дэвшлийн механизмыг бүрдүүлсэн байна. Сургуулийн хөгжлийн бодлоготой уялдан салбар сургуулийн бодлого тодорхойлогддог ба түүнтэй уялдан хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж тайлагнадаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг төлөвлөлтийн дагуу хийж сайжруулах ажлыг тасралтгүй хийдэг байна.
- Хичээлийн жилийн улирал болон төгсгөлд оюутан болон багшийн санал, хүсэлтийг авч хөтөлбөрийн хэрэгжилтэд тусгаж ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Мэдээллийн нэгдсэн сан бүхий удирдлага, мэдээллийн системийг нэврүүлсэн нь бодит мэдээлэлд үндэслэсэн судалгаа хийх, судалгаанд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийг 3 тэнхим хэрэгжүүлж байгаа бөгөөд тэнхим хоорондын сургалт, эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоо тааруу байгаагаас хамаарч үр дүн харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

Зөвлөмж:

- Салбар сургуулийн удирдлагын зүгээс Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа тэнхимүүдийн уялдаа холбоо сайжруулах, хөтөлбөрийн хөгжлийг дэмжсэн нэгдсэн удирдлага, менежментээр хангах, харилцан туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Олон улсын шинжлэх ухааны байгууллага, хүрээлэн, их дээд сургуулиуд, холбоодтой хамтран 20 гаруй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.
- Гадаад, дотоодын судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулдаг.
- Польш улсын Вроцлав хотын Дүрслэх урлаг, дизайны академи, БНХАУ-ын Хөх хотын багшийн сургууль, Улаан хадны их сургууль, ОХУ-ын Петербург хотын музейтэй тус тус хамтран ажиллаж, багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.
- БНХАУ-ын Эрээн хотын олон улсын дээд сургууль сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Дизайн технологи мэргэжлээр дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд CDIO стандарт, арга зүйг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэх үндэсний мастер багш нар бэлтгэгдээд байна.
- БНХАУ-ын Чиндоагийн их сургуультай хамтарсан гэрээний дагуу 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- МУБИС-ийн зүгээс сургалтын төлбөрийн тэтгэлгийг бодлогоор тасралтгүй дэмжиж холбогдох бодлогын баримт бичгийг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирсэн байна.
- Нийгэм олон нийтэд чиглэсэн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, хэвлэмэл ном гарын авлага, судалгааны үр дүн зэргийг түгээн дэлгэрүүлэхээс гадна үндэсний хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн, багш нарын сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зэргээр боловсролын бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- 2011 оноос төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулж, ажил тогтмолжиж байна.
- Хөтөлбөрийн оролцогчид-төгсөгчдийн эрэлтийн нэг хэсэг нь төгссөний дараах үргэлжилсэн сургалтын тогтолцоо, давтан сургалтын шаардлага юм. Үүнд тэнхимийн зүгээс төгсөгчдийн давтан сургалт зохион байгуулахаас гадна БСШУСЯ,

Боловсролын хүрээлэн, БМДИ-тэй хамтран ЕБС-ийн багш нарт арга зүй дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулж байна.

- Мөн магистрын хөтөлбөрөөр сүүлийн 3 жилд 12 магистр хамгаалсан байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн зүгээс сүүлийн жилүүдэд сургалтын төлбөрийн тэтгэлгийг бодлогоор тасралтгүй дэмжиж ирсэн. Энэ хүрээнд сүүлийн 5 жилд нийт 532 оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааг зөвхөн Хятад, Орос улсын их дээд сургуулиудтай хамтрах хүрээгээр хязгаарлаж байгаа нь учир дутагдалтай байна.

Зөвлөмж:

- Хамтын ажиллагааны төлөвлөгөөг судалгаанд суурилан боловсруулах, ирээдүйтэй стратегийг сонгох, бүрэлдэхүүн сургуулийн зүгээс гадаад хамтын ажиллагааг бодлогоор тасралтгүй дэмжих нь зүйтэй.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн орлогын 75%-ийг бүрэлдэхүүн сургууль зарцуулах эрхтэй байна.
- Бүрэлдэхүүн сургуулийн батлагдсан төсөв, зарцуулалтын тайланд 9 ангилал, 35 чиглэлээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан зардалд тоног төхөөрөмжийн, дадлагын, хичээл үйлдвэрлэлийн, уралдаан тэмцээний зардлыг тус тус авч үзсэн ба сүүлийн 4 жилийн байдлаар нийт орлогын 21-31 хувийг дээрх үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Нэг суралцагчийн сургалтын төлбөрийн орлогын 70 гаруй хувийг тухайн суралцагчийн зардалд зарцуулж буй дүр зүраг харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн дүүрэн хангахуйц санхүүжилтийн тогтвортой, найдвартай эх үүсвэртэй байхын тулд оюутны төлбөрөөс гадна санхүүгийн бусад эх үүсвэрийг хуулийн хүрээнд бий болгох, санхүүгийн менежментийн бодлого боловсруулах талд хангалтгүй ажилласан байна.

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт тайланд тодорхой харагдахгүй байна.

Зөвлөмж:

- ДУТС-ийн хэмжээнд сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх тусгай сан байгуулж, төсвийн тодорхой хувийг түүнд төсөвлөн, хөтөлбөрийн шинэчлэлийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн эрдэмтэн багш нарын бүтээл нь сургууль сурталчлах нэг хэлбэр болж ирсэн байна.
- 2019 оноос элсэлтийн маркетингийн ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- Хөтөлбөрт оролцогчдыг идэвхжүүлэх, хөтөлбөрийг сайжруулах санал санаачилгыг өрнүүлэх, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор тодорхой зорилтот төсөл, хөтөлбөр, хэлэлцүүлэг, хурал, семинар, олимпиад, уралдаан тэмцээн, үзэсгэлэнд оролцуулах байдал тогтмолжсон байна. Тухайлбал, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжээс 15 төсөл хөтөлбөр, олон нийтэд чиглэсэн 15 ажил, эрдэм шинжилгээний хурал 5, ном, гарын авлага, сэтгүүл 8, тэмцээн уралдаан, наадам, үзэсгэлэнг 20 удаа тус тус зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна.
- Цахим болон хэвлэмэл байдлаар хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийг тасралгүй хийж ирсэн байна. ДУТС-ийн хөтөлбөр сурталчилгааны хүрээнд зурагт хуудас, англи болон монгол хэлээр танилцуулга хэвлүүлэн түгээхээс гадна жил бүр өдөрлөг зохион байгуулж тогтмолжсон байна. (Цахим хуудасны холбоосууд болон хэвлэмэл танилцуулгууд)
- Цахим сурталчилгааг МУБИС-ийн болон ДУТС-ийн фейсбүүк хуудсаар хийж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна. Тухайлбал, сургуулийн фейсбүүк хуудас болон албан ёсны хэд хэдэн группээр төгсөгчид болон оюутнуудтай харилцах, эргэх холбоог идэвхжүүлэх, сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулдаг байна.
- Хөдөө орон нутгаас оюутан элсүүлэх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж хөтөлбөр, мэргэжлээ сурталчилдаг бөгөөд тус сургуулийн багш нараас аймгуудад ажиллаж өөрийн сургуулийн хөтөлбөрийг сурталчилж, оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулдаг байна.
- ЕБС-уудын ахлах ангийн сурагчдын дунд олимпиад зохион байгуулж ирсэн ба уг үйл ажиллагаа уламжлал болсон байна. Олимпиадад байр эзэлсэн сурагчдыг тус сургуульд элсэн суралцах эрхээр урамшуулдаг байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол авч төгсөлтийн дараах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

- Нийгэм олон нийтэд чиглэсэн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, хэвлэмэл ном гарын авлага, судалгааны үр дүн зэргийг түгээн дэлгэрүүлэхээс гадна олимпиад, уралдаан тэмцээн, үндэсний хэмжээний багш нарын сургалтыг үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зэргээр боловсролын бусад байгууллагатай хамтран ажиллаж байгаа нь сургууль, хөтөлбөрөө сурталчлах бас нэгэн үзүүлэлт болж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Зөвлөмж:

- ЕБС-уудын сурагчдаас гадна тэдний эцэг эх, багш нарт чиглэсэн хөтөлбөр сурталчилгааны ажлыг идэвхжүүлэх.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол авч төгсөлтийн дараах сургалтын бодлогыг улам боловсронгуй болгох.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн веб сайтын /www.msue.edu.mn/ хөгжүүлэлт, үйл ажиллагаа нь төрийн байгууллагын веб сайтад тавигдах MNS-6285 стандартад нийцсэн байна.
- МУБИС нь веб сайтаас гадна facebook, youtube, радио, телевиз, сонин сэтгүүлээр дамжуулан сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтэд зориулан зохион байгуулсан ажлуудыг ил тод мэдээлж иржээ.
- Бүрэлдэхүүн сургуулиуд мэдээллийг суралцагчдад болон олон нийтэд хүргэх зорилгоор танилцуулга мэдээллийн сайтаар дамжуулан нээлтэй хүргэж байна. Мөн мэдээллийг постер байдлаар хэвлэн анги танхим, сургуулийн орчинд байршуулж нийтийн хүртээл болгодог байна.
- Сургуулийн веб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагааг хангах үүднээс захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг ажиллаж сайт хөгжүүлэлтийг хийдэг учраас вэб сайтын мэдээлэл, танилцуулга тогтмолжсон. (Цахим мэдээллийг түгээх ажил жигдэрсэн ба мэдээллийн агуулга, багтаамж баяжилт тасралтгүй хийгдэж байна. 7 хоногт дунджаар 20-30 орчим мэдээ, мэдээлэл тавигдаж байна)

Шалгуурыг хангасан байдал:

Зөвлөмж:

- ДУТС-ийн вэб сайтад Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүд, сургалтын төлөвлөгөө, хичээлийн товч танилцуулга, чанарын батлагаажуулалтын үнэлгээний тайлан зэрэг сургалттай холбоотой зайлшгүй шаардлагатай мэдээллийг байршуулах, тасралтгүй шинэчлэх ажлыг зохион байгуулах.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 тоот тогтоолын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувийг, элсэлтийн ерөнхий шалгалтад 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь сургалтын төлбөрөөс Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний дагуу чөлөөлдөг.
- Засгийн газрын 70, 100 хувийн өндөр онооны тэтгэлгээр суралцах болзол хангасан элсэгч хувийн зардлаар суралцах тохиолдолд тухайн хичээлийн жилийн суурь төлбөрийн 50 хувийг нь хөнгөлөх боломжтой.
- МУБИС-ийн ЭЕШ-ын 500-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгох заалттай. (Элсэлтийн журмын 3.22)
- МУБИС-ийн ЭЕШ-ын 550-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 70 хувийн тэтгэлэг олгох заалттай. (Элсэлтийн журмын 3.23)
- Дизайн зураг зүйн багш мэргэжлээр элсэгчдийн элсэлтийн шалгалтын сүүлийн 5 жилийн оноо 490-510 оноо, дундаж 500 оноотой элсэгч тус хөтөлбөрийг сонгон суралцаж байна. Засгийн газраас багш боловсролыг дэмжиж буй өндөр онооны тэтгэлэгт 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр суралцагч 103 оюутан хамрагджээ.
- Дүрслэх урлагийн багш мэргэжлээр элсэгчдийн элсэлтийн шалгалтын сүүлийн 5 жилийн оноо 400-780 оноо, дундаж 511 оноотой элсэгч тус хөтөлбөрийг сонгон суралцаж байна. Засгийн газраас багш боловсролыг дэмжиж буй өндөр онооны тэтгэлэгт 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр суралцагч 70 оюутан хамрагджээ.
- Дизайн технологийн багш мэргэжлээр элсэгчид математик, монгол хэлний болон ур чадварын шалгалт өгнө. Засгийн газраас багш боловсролыг дэмжиж буй өндөр онооны тэтгэлэгт 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр суралцагч 153 оюутан хамрагдсан бол эрэгтэй 5 суралцагч эхний нэг жилийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлжээ.
- Авьяас, ур чадвар шаардах Багш, урлагийн боловсрол хөтөлбөрөөр элсэх бол ерөнхий шалгалтаас гадна ур чадварын шалгалт өгнө.
- Техник-технологи, зохион бүтээх болон зураг дизайны чиглэлээр хот, аймгийн олимпиад, уралдаан, үзэсгэлэн /техник, технологийн олимпиад, робот, техник, спортын төрлүүд, зураг төсөл, дизайны нэрэмжит олимпиадууд, хувцас загварын

уралдаан “Үнсгэлжин”, сурагчдын бие даасан үзэсгэлэн/-д 1-р байр эзэлсэн сурагчийг тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн тоонд багтаан элсүүлж болно.

- Сүүлийн 5 жилийн хугацаанд Дүрслэх урлагийн багш мэргэжлээр элсэгчийн тоо буурч байгаа бөгөөд элсэгчдийн 95 хувь нь орон нутгийн суралцагчид байна. Энэхүү байдалд тэнхим дүн шинжилгээ хийж Улаанбаатар хотоос элсэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлсэн байна. Тухайлбал, Нийслэлийн ЕБС-ийн сурагчдад өөрийн хөтөлбөрийг сурталчлах, төгсөх ангийн оюутны үйлдвэрлэлийн дадлагаар дамжуулж хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг хийж байна.
- Гадаад оюутан элсүүлэх журмын дагуу БНХАУ-ын Өвөрмонголын их, дээд сургуультай хамтран 2+2 хөтөлбөр хэрэгжүүлж элсэлт авч байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөх ангийн оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагын тайланг үзэсгэлэн байдлаар гаргаж хөтөлбөрөөр суралцаж буй нийт суралцагчдад танилцуулдаг нь шинээр элссэн оюутнуудад цаашид амжилттай суралцах сэдэл тэмүүллийг өгдөг.
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу сургалтын төлбөрийн хөнгөлөлт олон хэлбэрээр хэрэгждэг.

Анхаарах асуудал:

- Шинээр элсэгч оюутанд зориулсан оюутны гарын авлагыг тогтмол гаргаж, мэдээллээр хангах ажил 2013 оноос хойш хийгдээгүй.

Зөвлөмж:

- Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 тоот тогтоолыг сонирхогч талуудад (суралцагч, багш, эцэг эх, олон нийтэд) маш сайн сурталчлан таниулах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээс сонголт хийх, сургалтын явцад оюутны сурах, хүмүүжих үйл явцад дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах чиг үүрэг бүхий “Ангийн зөвлөх багш”-ийг сургуулийн захирлын тушаалаар жил бүрийн 08 сарын 15-ны дотор томилдог. Ангийн зөвлөх багшийн чиг үүргийг МУБИС-ийн Багшийн ажиллах журмын 3.7.1-3.7.9 зохицуулсан бөгөөд томилогдсон багш 4 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутанд зөвлөн тусалж хамтран ажиллан

улирал бүр ажлын төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлд тэнхимийн эрхлэгч, сургуулийн захирал хяналт тавьж ажилладаг.

- Хөтөлбөрийн албанаас анги удирдсан зөвлөх багшийн үйл ажиллагааны талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон ажиллаж хичээлийн жилийн төгсгөлд багшид 1 кр цагийн урамшуулал олгодог байна.
- ДУТС-ийн хөтөлбөрийн албанаас жил бүр хичээлийн жилийн эхэнд “Оюутны хөгжлийн ажлын төлөвлөгөө” гаргаж, биелэлтийг ханган ажилладаг байна. Хөгжлийн төлөвлөгөөнд уламжлалт ажлууд тусгагдахын зэрэгцээ хичээлийн жилийн онцлог бүхий тодорхой ажлууд тусгагдан төлөвлөгөөний гүйцэтгэлийг жилд 2 удаа дотоод хяналт, үнэлгээ шинжилгээний алба болон сургуулийн удирдлагын нэгж үнэлж дүгнэдэг.
- Сонсон хөгжихүй сарын аяны хүрээнд “Харилцааны соёл”, “Хотын соёл” зэрэг сэдвээр зочин багш урьж лекц уншуулж хамтран ажилладаг байна.
- Суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадварыг дээшлүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.
- ДУТС-ийн оюутны хөгжлийн албанаас жил бүр оюутнуудад зориулж хувь хүний хөгжлийг дэмжих сургалтуудыг зохион байгуулж, мэдээлэл өгдөг байна. Тухайлбал, эрүүл аж төрөх ёс, эрүүл хооллолт, ёс суртахуун, харилцааны талаар сургуулийн эмч, багш, ахмад багш, ур бүтээлчидтэй танхимын болон танхимын бус хэлбэрээр уулзалт ярилцлагыг зохион байгуулдаг.
- Сар бүр тэнхимийн нэрэмжит ажлыг суралцагчдын дунд зохион байгуулж шалгарсан оюутнуудыг алдаршуулдаг нь тэдний сурах идэвх, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлдэг үр дүнтэй ажил болжээ.
- Суралцагчдын судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих чиглэлээр зөвлөн туслах багш, мэргэжлийн багш нартай хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна. Тухайлбал, 2018-2019 оны хичээлийн жилд Монголын Дизайнеруудын холбооноос зохион байгуулдаг “Хаврын гоёл, дизайн сургалт наадам”-ын эрдэм шинжилгээний хуралд 2+2 хөтөлбөрөөр суралцаж буй оюутан Б.Угтмал “Пандора цүнхний дизайн шийдэл” сэдвээр оролцож тэргүүн байр эзэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн захиргаанаас ангийн зөвлөх багшийн үйл ажиллагаа, үр дүнг тооцон эргэх холбоотой маш сайн хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд зохион байгуулж буй ажил өнөө цагийн оюутны эрэлт, хэрэгцээнд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчдын эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгаа авах замаар зөвлөн туслах үйлчилгээг олон талт хэлбэрээр зохион байгуулах талд анхаарах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- **Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд** дизайны боловсролыг түгээн дэлгэрүүлэх, мэдлэгт тулгуурлан баялаг бүтээх, уран бүтээлч сэтгэлгээ, хандлага төлөвшүүлэх, оюутны уран бүтээлийг сурталчлах зорилго бүхий “Бүтээлч дизайн” оюутан клуб хичээллэдэг. Клубийг тус тэнхимийн багш М.Уранмандах чиглүүлж 3 дахь жилдээ ажиллаж байна. Мөн оюутны “Creative design” клубийн үйл ажиллагааны үр дүнд Монгол улсад цөөхөн үлдсэн мазаалайг аврах сайн үйлсийн аянд нэр бүхий оюутнууд нэгдэж “Маззо” үзэсгэлэн гаргасан.
- Суралцагчдын ирээдүйн карьер хөгжлийг дэмжих чиглэлээр дизайны чиглэлийн мэргэжлийн уралдаан тэмцээн, нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг оюутнуудын дунд зохион байгуулдаг байна. Тухайлбал, “Бумбардай” хүүхэлдэйн киноны зураач Б.Мөнхбат, Мазаалай сангийн тэргүүнтэй чөлөөт уулзалт ярилцлагуудыг зохион байгуулсан, Монголын Дизайнеруудын холбоо “Хаврын гоёл”, ШУТИС-ийн “Алтан хулгана” зэрэг мэргэжлийн чиглэлийн уралдаанд оюутан суралцагчид оролцжээ.
- Оюутны хөдөлмөрийн биржтэй хамтран ажилладаг бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд дизайн зураг зүй мэргэжлийн суралцагч оюутнуудаас 180 оюутныг цагийн болон үндсэн ажлын байранд зуучилсан, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас зохион байгуулдаг “Таны амжилтын эхлэл” өдөрлөгт төгсөх ангийн оюутнуудыг хамруулдаг бөгөөд 20 гаруй ажил олгогч, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.
- Оюутны сурах, хөгжих орчныг нэмэгдүүлэх, дэмжих чиглэлээр “Оюутны хөгжлийн төв”-ийг шинээр байгуулж ажилласан нь үр дүнтэй ажлуудын нэг болсныг ярилцлагын явцад оюутны цөөнгүй төлөөлөл дурдаж байсан.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд дизайн зураг зүй мэргэжлийн хувьд дунджаар 47 оюутан урамшуулал, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан бөгөөд жил ирэх тутам хөнгөлөлт, тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тоо нэмэгдэж байна. Мөн энэ мэргэжлээр суралцаж буй 8 оюутан тэтгэлэгтэй багшлах дадлагын хөтөлбөрт хамрагдсан байна.
- **Дүрслэх урлагийн багш мэргэжлийн хувьд** зураасан зургийн болон монгол зургийн чиглэлээр нийт 3 клуб хичээллэж байгаа бөгөөд нийт 91 оюутан хамрагдсан байна.
- Суралцагчдыг олимпиад, уралдаан тэмцээнд оролцоход тэтгэлэгт хамруулах болон оролцож буй уралдаан тэмцээнийг санхүүжүүлэх, оролцогч оюутныг удирдан чиглүүлэх, дугуйлан, клубээр дамжуулж ур чадварыг хөгжүүлэх, хамтарсан болон бие даасан үзэсгэлэн, тайлан гаргахад анхаарч ажилладаг байна. Тухайлбал, жил бүр зохион байгуулагддаг “Алтан хулгана”, “Дүрслэх геометрийн улсын олимпиад”, “Хаврын гоёл”, “Техник технологийн улсын олимпиад”, “Багшлах ур чадварын

олимпиад” зэрэг уралдаан тэмцээнд суралцагчдыг оролцоход санхүүгийн бодит дэмжлэгийг тогтмол үзүүлдэг.

- Сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар, дүрслэх урлагийн багш мэргэжлийн 32 оюутан урамшуулал, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байна.
- **Дизайн технологийн багш мэргэжлийн хувьд** “Double Tech” техникийн загвар, роботын чиглэлийн дугуйлан амжилттай үйл ажиллагаа явуулдаг. Тус клубт суралцагч өөрийн сайн дурын үндсэн дээр элсэх бөгөөд техникийг олон талын мэдлэг, багаар ажиллах чадвар, ажил мэргэжлийн чиг баримжаатай болдог байна.
- Технологийн тэнхим хүсэлт гаргасан сургуульд захиалгын дагуу шинээр төгссөн төгсөгчдийг үндсэн ажлын байранд тогтмол зуучилдаг. Тухайлбал, тус хөтөлбөрөөр төгсөгчид Орчлон, Гётё, Олонлог, Монгени, ХААИС, ХУИС зэрэг сургуульд үр бүтээлтэй ажиллаж байгаагаас гадна ОУ-ын хүүхдийн Найрамдал төвийн шинэ жилийн тайз засал болон ханын зураг зурах ажилд оюутнуудыг зуучилж ажиллуулсан, тус тэнхимийн багш нарын хэрэгжүүлж буй “Роботын дизайнчлал” төсөлд 2 суралцагчийг хамруулан ажиллажээ.
- Тус хөтөлбөрөөр төгсөгч эрэгтэй оюутны эрэлт хэрэгцээ өндөр байдаг бөгөөд 3.5 жилээр төгсөх оюутнуудыг үндсэн ажилд зуучилсан. Тухайлбал, Өсвөрийн зохион бүтээх лаборатори ахлах сургууль болон Гётё сургуульд нэр бүхий оюутнуудыг багшийн ажилд зуучилж оруулжээ.
- Тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд улсын хэмжээнд зохион байгуулагддаг олимпиад уралдаан тэмцээнд амжилттай оролцдог. Тухайлбал, 2017 онд Зүүн өмнөд Азийн телевизүүдийн холбооноос уламжлал болгон зохион байгуулагддаг “ABU robocon 2017” тэмцээнд МУБИС-ийг төлөөлж амжилттай оролцсон байна.
- Дизайн технологийн багш мэргэжлийн оюутнуудын дунд техник сонирхогчдын тэмцээнийг уламжлал болгон жил бүр зохион байгуулж ирсэн бөгөөд амжилт гаргасан оюутнуудад журмын дагуу кредит цагийн тэтгэлэг олгодог байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд энэ мэргэжлээр дунджаар 100 гаруй оюутан урамшуулал, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан бөгөөд жил ирэх тутам хөнгөлөлт, тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тоо нэмэгдэж байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудыг үндсэн болон цагийн ажилд сайн зуучилдаг.
- Мэргэжлийн чиглэлийн улсын хэмжээний олимпиад, уралдаан тэмцээнд суралцагчдыг бэлтгэж тогтмол оролцуулдаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын асуудлыг МУБИС-ийн захирлын оюутны урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтийн 7.17 дахь хэсэгт тусган өгсөн хэдий ч энэ чиглэлийн хийгдсэн ажлын талаар мэдээ тайлан гаргаагүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчдын олон нийтийн үйл ажиллагааны оролцоо, сайн дурын байгууллагын үйл ажиллагааны талаар тэнхим тус бүрээр бус хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн төлөвлөлт хийж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнадаг болох.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн захирлын 2015 оны А/172 тоот тушаалаар батлагдсан сургалтын журмын дагуу суралцагчийн шилжилт, хөдөлгөөний асуудлыг зохицуулдаг.
- Хөтөлбөрийн албанаас шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж ажилладаг бөгөөд сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар шилжилт хөдөлгөөний асуудлыг хэлэлцдэг.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд тус хөтөлбөрөөр элсэгчдийн 30 орчим хувь нь шилжилт хөдөлгөөнд хамрагдсан дүн мэдээ байна.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр элсэгчдийн 30 орчим хувь шилжилт хөдөлгөөн хийж байгаад дүн шинжилгээ хийж учир шалгааныг тодорхойлон, хариу арга хэмжээ авах талд ямар ажил зохион байгуулсан нь тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөнийг багасгах талаар тодорхой бодлого барьж, шинэ менежменттэй ажиллах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн захирлын 2015 оны А/172 тоот тушаалаар батлагдсан сургалтын журмын 4.14.13 дах заалт болон төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн МУБИС-ийн захирлын тушаалаар диплом, энгэрийн тэмдэг олгодог.

- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтэд МУБИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн алба, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн алба, чанарын баталгаажуулалт, мониторингийн алба тус тус хөндлөнгийн хяналт тавьж ажилладаг байна.
- Төгсөлтийн баримт бичгийн эх хувийг цахим системд оруулдаг бөгөөд суралцагч төгсөлтийн баримт бичгээ цахим хэлбэрээр шалгах боломжийг бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийн баталгаажилтыг цахим хэлбэрээр шалгах боломжийг бүрдүүлсэн.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн захирлын 2015 оны А/172 тоот тушаалаар батлагдсан “Багшийн ажиллах журам”-ыг баталж МУБИС-ийн багшийн эрх үүрэг, багш шинээр авах, ажиллуулах, чөлөө олгох, албан тушаалын зэрэглэл тогтоох, багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, түүнд тавигдах шаардлага, багшийн ажлыг үнэлэх, урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулжээ.
- МУБИС-ийн захирлын 2015 оны А/172 тоот тушаалаар батлагдсан “Багшийн ажиллах журам”-д багшийн ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцох бөгөөд багшийн зэрэглэлийг профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш байхаар тусгасан.
- “Багшийн ажиллах журам”-д зааснаар тэнхимийн эрхлэгч 11 кр, профессор 11 кр, дэд профессор 13 кр, ахлах багш 15 кр, багш 16 кр, дадлагажигч багш 18 кредит цагийн сургалтыг заавал биелүүлэхийг тусгасан бөгөөд тус тэнхимийн багш нарын цагийн ачаалалд хийсэн судалгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд зарим багшийн А буюу сургалтын цагийн ачаалал өндөр байгаа нь ажиглагдсан.
- МУБИС-ийн захирлын 2018 оны А/249 тоот тушаалаар “Багшийн хөгжлийн хөтөлбөр /2019-2024/” батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд их сургуулийн багшийн үндсэн үүргийг хянан тодотгож, түүнд нийцүүлэн багшийг хөгжүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд цогц хандах

шаардлагыг тусгасан бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын товч тайлантай.

- Доктор зэрэгтэй багшийн эзлэх хувь Д33 мэргэжилд 44%, ДУ мэргэжилд 22%, ДТ мэргэжилд 36% байна.
- Багш суралцагчдын тооны харьцаа сүүлийн 5 жилийн дунджаар Д33 мэргэжилд 1:18, ДУ мэргэжилд 1:11, ДТ мэргэжилд 1:22 байна. (МУБИС-ийн хөгжлийн бодлого 2014-2024 төлөвлөлтөд 1:21 байхаар тусгасан).
- Эрхэлж буй ажил, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ идэвх санаачилгатай, бүтээлчээр биелүүлж, онцгой амжилт гаргасан багш нарыг багшийн ажиллах журмын 5.4 дэх хэсгийн үндэслэн шагнаж урамшуулдаг. Тус журмын 5.4.5 дах хэсэгт зааснаар дараах шагналыг багш нарт олгодог байна. Үүнд: МУБИС-ийн захирлын нэрэмжит шагнал, МУБИС-ийн “Оны шилдэг багш /3 номинаци/” зэрэг шагналаар шагнаж урамшуулахаас гадна байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон төрийн дээд шагналд нэр дэвшүүлэн шагнуулдаг.
- Сургуулийн докторын хөтөлбөрт суралцаж байгаа багш нарын сургалтын төлбөрийн 50 хувийг байгууллага хариуцах бөгөөд улирал бүр багш нарт үр дүнгийн үнэлгээ хийж үндсэн цалингийн 15 хувийг олгодог.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Докторын хөтөлбөрт суралцаж байгаа сургуулийн багш нарын сургалтын төлбөрийн 50 хувийг байгууллага хариуцдаг.

Зөвлөмж:

- Зарим тэнхимийн хувьд эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувийг дээшлүүлэх, багш оюутны тоог зохистой харьцаанд байлгахад анхаарах.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн хуулийн холбогдох заалтыг үндэслэн Багшийн хөгжлийн төв байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлээр үйл ажиллагааны ерөнхий төлөвлөлтийг гарган ажиллаж байна.
- **Дизайн зураг зүйн тэнхимийн хувьд** багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг хичээлийн жилээр гаргаж хэрэгжилтийг улирал бүр тэнхимд тайлагнадаг. Мөн багш нар 3 багт хуваагдан судалгааны ур чадвараа хөгжүүлэн ажиллаж байна.
- Тэнхимийн багш нар гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагддаг бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд нэг багш солилцооны хөтөлбөрт (БНХАУ), хэд хэдэн багш Польш болон ОХУ-д урт болон богино хугацааны сургалтад хамрагджээ.

- Дотоодод зохион байгуулагдсан багшлахуйн ур чадварыг дээшлүүлэх CDIO хөтөлбөрийн сургалтад тэнхимийн бүх багш нар хамрагдсан байна.
- **Дүрслэх урлагийн тэнхимийн хувьд** “Бээжин биенналь 2017, 2019” үзэсгэлэнд 3 багш, “Норд Арт” ОУ-ын үзэсгэлэнд 2 багш, бие даасан уран бүтээлийн үзэсгэлэнгээ гадаадад 1 багш, Монголд 2 багш 6 удаа, тэнхимийн нийт уран бүтээлч багш нар хамтарсан тайлан үзэсгэлэнгээ 3 удаа тус тус гаргасан байна.
- Тус тэнхимийн багш нарын 80 хувь нь мэргэжлийн холбоодын гишүүн, удирдах зөвлөлд ажилладаг.
- Сүүлийн 2 жилийн хугацаанд 4 багш ОХУ-д өөрийн зардлаар мэргэжил дээшлүүлсэн бол STEAM болон үнэлгээний арга зүй, CDIO сургалтад тэнхимийн бүх багш нар хамрагджээ.
- **Дизайн технологийн тэнхимийн хувьд** 5 багш Японы Хокайдогийн Боловсролын их сургуулийн профессор багштай хамтарсан сургалтыг 5 аймагт зохион байгуулж мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлсэн.
- Багш нар хуваарийн дагуу нээлттэй хичээл заадаг.
- Тэнхимийн багш нар сургалтын цөм хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалт, STEAM, CDIO зэрэг сургалтад дотоодод хамрагдсан бол БНХАУ, ОХУ, Сингапур зэрэг улсад нэр бүхий багш нар богино хугацааны сургалт, үзэсгэлэн яармаг, ЭШ-ний хуралд оролцсон бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд ОУ-ын ЭШ-ний хуралд нийт 12 илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Дүрслэх урлагийн тэнхимийн хувьд багш нар гадаад, дотоодод үзэсгэлэнд оролцох, дүрслэх урлагийн мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах талд санаачилгатай ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай байна.

Зөвлөмж:

- МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- **Дизайн зураг зүйн тэнхимийн хувьд** дизайны чиглэлээр сургалт зохион байгуулдаг их, дээд сургуулиудын дунд “Хаврын гоёл” ЭШ-ний хурлыг 2017, 2018 онд бие даан удирдан зохион байгуулсан.

- Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 24 илтгэл хэлэлцүүлсэн, 6 өгүүлэл хэвлүүлсэн байна.
- 2018 онд ОХУ-ын Буриадын үндэсний музей, Сибирийн салбараас зохион байгуулсан ОУ-ын ЭШ-ний хуралд багаараа 5 илтгэл амжилттай хэлэлцүүлсэн.
- Дотоодын санхүүжилт бүхий 6 төслийг амжилттай хэрэгжүүлж, олон улсын нэг төсөлд 2 багш хамрагдан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт багш нарын 44% нь төсөл хөтөлбөрт хамрагджээ.
- МУБИС-ийн хэрэгжүүлсэн инновацын төсөлд 2 багш удирдагчаар оролцсон бол тус тэнхимийн 3 багш давхардсан тоогоор 14 удаа үзэсгэлэн гаргаж ажиллажээ.
- **Дүрслэх урлагийн тэнхимийн хувьд** ЕБС-ийн суурь боловсролын дүрслэх урлаг заах арга зүй, уран зургийн өнгө, керамик урлалаар сургалтын хэрэглэгдэхүүн хийх зэрэг төслийг МУБИС-ийн 50-100 хүртэлх хувийн санхүүжилтээр амжилттай хэрэгжүүлсэн.
- Тэнхимийн багш нар 2018-2019 оны хичээлийн жилд нийт 11 илтгэл хэлэлцүүлж, 4 өгүүлэл хэвлүүлсэн байна.
- **Дизайн технологийн тэнхимийн хувьд** суурь болон хавсарга судалгааны чиглэлийг тодорхойлж багш бүр судалгааны ажил гүйцэтгэн тодорхой амжилтуудыг гаргаж байна.
- МУБИС-ийн дотоодын төслөөр сургалтын хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх лазераар зүсэгч технологи, 3D хэвлэх технологи, электрон плат ашиглах, CNC сургалтын бага оврын машин ашиглах зэрэг төслүүдийг хэрэгжүүлсэн.
- Зарим багш мэргэжлийн хичээлийн хүрээнд ашиглагдах сурах бичиг, гарын авлага боловсруулж, хэвлүүлсэн байна.
- Чансаа өндөртэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх тал дээр анхаарч зарим судлаачтай хамтран ажиллаж байна.
- Оюуны өмчийн бүтээлийн гэрчилгээтэй 3 багш ажиллаж байгаа бөгөөд тэнхимийн багш нар сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 12 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Профессор багш нарын эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүллийн тоо, чансааг харуулсан нэгдсэн судалгаа гаргаагүй байна.

Зөвлөмж:

- Цаашид МУБИС-ийн судалгааны их сургууль болох төлөвлөлттэй уялдаатайгаар багш нарын судалгааны чадавхыг сайжруулах урт хугацааны төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн жилд багш 2 удаа өөрийн үнэлгээний тайлан бичиж хамт олны өмнө тайлагнадаг бөгөөд бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхим, профессорын баг үнэлж дүгнэдэг ./тайланд тусгаснаар/
- Хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөрийн албанаас хийдэг бөгөөд багшийн вэб дэх оюутнаас сэтгэл ханамжийн судалгааг 2 чиглэлийн нийт 14 асуултаар авч үнэлгээ хийдэг.
- Багш бүрийн өөрийн хавтас бүрдүүлэлт хийсэн.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг ямар шалгуураар авч, хэрхэн үнэлж дүгнэсэн нь нотлох баримтаар илрээгүй.
- Багшийн хавтас бүрдүүлэлтэд нэгдсэн шаардлага тавиагүй. Тэнхим бүрээр чанар болон бүрдэл хэсэг нь ялгаатай байна.

Зөвлөмж:

- Багш сургалт, эрдэм, шинжилгээ, олон нийтийн ажлын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа ямар шалгуур шаардлагын дагуу өөрөө үнэлж тайлагнах, түүнийг хэн, хэрхэн дүгнэх үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх.

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- 2014 оноос чанарын баталгаажуулалт мониторингийн алба байгуулан сургалт, эрдэм шинжилгээ, суралцах орчин, санхүү, хүний нөөцийн чадавхын чиглэлээр дотоод үнэлгээ баталгаажуулалт хийхээр төлөвлөн холбогдох дүрэм журам, зааврыг батлан мөрдөж ирсэн байна.
- Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах замаар чанарын баталгаажуулалт хийх ажлыг эхлүүлж холбогдох нотолгоог бүрдүүлсэн.

- Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд чанарын баталгаажуулалтын тогтолцоог PDCA циклтэй холбон загварчилсан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд, тэдгээрийн ач холбогдлын зэрэглэлийг тогтоох зорилгоор ӨМӨЗО-ы Багшийн сургууль, Монгол улсын хөтөлбөрт оролцогч талуудыг хамруулан нийт 160 хүнээс санал асуулга авч үр дүнг боловсруулж дүгнэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн хэмжээнд суралцагчдын ахиц дэвшлийн үнэлгээг гарааны түвшинд, 2-р курст, 3-р курст, төгсөх курст гэсэн 4 шатлалаар үнэлэх төлөвлөлт хийж, тодорхой түвшинд хэрэгжүүлж ирсэн байна.

Анхаарах асуудал:

- Дотоод чанарын баталгаажуулалтыг сургалт, эрдэм шинжилгээ, суралцах орчин, санхүү, хүний нөөцийн чадавхын чиглэлээр хийхдээ ямар ямар шалгуураар, хэрхэн үнэлэх, үнэлгээний шатлал ямар байх, зорилтот түвшин ямар байх талаар бүрэн төлөвлөөгүй, чанарын үнэлгээг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүн гаргасан, цаашид хэрхэн сайжруулах талаар төлөвлөлт, үр дүн хангалтгүй.
- Үнэлгээнд, шаардлагатай оролцогч талуудыг татан оруулах талаар хангалтгүй ажилласан байна.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгийг үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу үнэлэх иж бүрэн загварыг бий болгох, түүнийгээ хэрэгжүүлэх талд анхаарч ажиллах.
- Сургалтын чанарт өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлж хэвших.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- **Дизайн зураг зүй мэргэжлийн хувьд** төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2016-2019 оны хоорондох төгсөгчдийг хамруулан хийж графикаар үр дүнгүүдийг гаргасан байна.
- Мөн ажил олгогчид боловсон хүчнээ хэрхэн олж авдаг, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг тус тус авч тайлагнасан байна.

- **Дүрслэх урлагийн багш мэргэжлийн хувьд** төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2014-2019 оны хоорондох төгсөгчдийг хамруулан гаргасан байна.
- **Дизайн технологийн багш мэргэжлийн хувьд** төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2014-2019 оны хоорондох төгсөгчдийг хамруулан гаргасан байна.
- Багшийн талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал:

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчид, төгсөгчид, багш нарын төлөөлөлтэй уулзах үед тус хөтөлбөрийн төгсөгчид сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангаж байгаа нь харагдаж байлаа.

Анхаарах асуудал:

- Магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу хийгдэх ёстой дараах судалгаанууд бүрэн хийгдээгүй байна. Үүнд:
 - Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
 - Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
 - Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ
 - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлийг тус бүрээр нь үнэлэх зорилгоор авсан судалгаа, дүн шинжилгээ

Зөвлөмж:

- Дээр өгүүлсэн шаардлагатай судалгаануудыг тодорхой давтамжаар зохион байгуулж, үр дүнг хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтад ашигладаг болох.
- Оролцогч талуудын шууд ба шууд бус үнэлгээгээр хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийн ач холбогдол болон гүйцэтгэлийн түвшинг тодорхойлж, тасралтгүй сайжруулах тогтолцоог бүрдүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2018 онд МУБИС байгууллагын түвшинд БМИҮЗ-өөр 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн.
- Дизайн технологийн багш мэргэжлийг 2012 онд БМИҮЗ-өөр 5 жилээр магадлан итгэмжлүүлж байсан.

Шалгуурыг хангасан байдал:

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгийг хамруулан өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж байсан тухай мэдээ, тайлан байхгүй.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох судалгаа, баримт байхгүй.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан, мэдээ хангалтгүй.
- Дотоод, гадаадад дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгаа, дүн шинжилгээ гаргаагүй.

Зөвлөмж:

- Олон улсын түвшинд Багш, урлагийн боловсрол хөтөлбөрт ямар шалгуур, шаардлага тавьдаг талаар судлан, түүний дагуу хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийх.
- Бакалавр, магистрын сургалтын залгамж холбоог сайжруулах

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:

ДУГНЭЛТ

МУБИС-ийн ДУТС-ийн “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрт шинжээчдийн зүгээс дараах нэгдсэн үнэлгээг өгч байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт				
2	Сургалтын үйл ажиллагаа				
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл				
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт				
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа				
6	Багшийн үйл ажиллагаа				
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт				
Дүгнэлт					

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУБИС-ийн ДУТС-ийн “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад байгаа тул “ гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/ Н.Эрдэнэхүү/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Д.Уранчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Б.Нацагдорж/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ С.Отгонтуяа/

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	МУБИС-ийн ДУТС
Хөтөлбөрийн нэр	“Багш, урлагийн боловсрол”
Хөтөлбөрийн индекс	011404
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Юнескогоос гаргасан ISCED-F-2013 ангилалын дагуу “Багш урлагийн боловсрол” хөтөлбөр нь багш боловсролын суурьтай, дотроо 3 мэргэжил бүхий сургалтын хөтөлбөр гэдэг талаас нь харж бүх сонирхогч, оролцогч талуудаас санал зөвлөмж авах замаар төгсөгчийн чадамжийг зөв тодорхойлж, гадаад, дотоодын ижил төстэй шилдэг хөтөлбөрүүдтэй харьцуулан тэдний сайн туршлагыг нэвтрүүлэн, мэргэжил хоорондын уялдаа холбоог хангасан байдлаар хөтөлбөрийн төлөвлөлт хийх.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ҮДСБ-ын онол арга зүйн дагуу харилцан уялдаатай суралцахуйн үйлд тулгуурлан хичээлийн түвшинд суралцахуйн үр дүнг зөв тодорхойлох, түүнийг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэх, үнэлгээг сургалтын агуулгыг бус суралцахуйн үр дүнг үнэлэхэд чиглүүлж шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх. Мөн сургалтын шинэлэг арга зүйг хичээлээрээр дамжуулан оюутнуудад эзэмшүүлэхэд багш бүр анхаарч ажиллах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> Номын сангийн орчин, үйлчилгээг орчин үеийн уншигч оюутнуудын сэтгэл зүйн онцлог, суралцах арга барил, хүсэл сонирхолд нийцүүлэн шинэчлэн сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлэх.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ДУТС-ийн удирдлагын зүгээс Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа тэнхимүүдийн уялдаа холбоо сайжруулах, хөтөлбөрийн хөгжлийг дэмжсэн нэгдсэн удирдлага, менежментээр хангах, харилцан туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Төгсөгчдийн ажлын байрны бодит хэрэгцээг тодорхойлох, элсэлтийг нэмэгдүүлэхэд БСШУСЯ-наас дэмжлэг авах. Шилжилт хөдөлгөөнийг багасгах талаар тодорхой бодлого барьж, шинэ менежментээр ажиллах.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> МУБИС-ийн судалгааны их сургууль болох төлөвлөлттэй уялдаатайгаар багш нарын судалгааны чадавхыг сайжруулах урт хугацааны төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх. Багш сургалт, эрдэм, шинжилгээ, олон нийтийн ажлын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа ямар шалгуур шаардлагын дагуу өөрөө

	<p>үнэлэх, тайлагнах, түүнийг хэн, хэрхэн дүгнэх үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх</p>
<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> • Шууд ба шууд бус үнэлгээг доороос дээш зарчмаар буюу хичээлийн суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, боловсролын зорилт, сургуулийн эрхэм зорилго, алсын хараа гэсэн дарааллаар хийж сургалтын чанарыг баталгаажуулах, тасралтгүй сайжруулах тогтолцоог хэвшүүлэх.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Мэргэ- жил	Цол зэрэг	Албан тушаал	Заадаг хичээл	Багшил- сан жил

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1.	Б.Ариунзаяа	3	Улаанбаатар хотын
2.	Э.Долгоржав	3	бүтэн өнчин
3.	М.Шинэцэцэг	4	Орон нутаг
4.	Н.Туул	4	Орон нутаг
5.	Лхагватөмөр	4	Орон нутаг
6.	Эрдэнээул	4	Улаанбаатар хотын
7.	Нандинчимэг	4	Дотуур байр
8.	Мустафа	4	Орон нутаг
9.	Цэвээнравдан	4	Дотуур байр
10.	Л.Түвшинтөр	1	Улаанбаатар хотын
11.	Х. Үүрийнтуяа	2	Орон нутаг
12.	Ч.Амарсайхан	3	Орон нутаг
13.	Т.Наяннаст	4	Орон нутаг
14.	Э.Оюун-Эрдэнэ	2	Орон нутаг

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал
---	-----------	---------------------------

1.	Р.Батхуяг	Сургалтын менежер
2.	Алтангэрэл	6-р сургуулийн захирал
3.	Сайн гэрэл	Шинэ Монгол сургууль
4.	Г.Энхтогоо	ӨЗБТ сургуулийн захирал
5.	Г.Энхрийцэцэг	Өвөрхангай, Хархорин сумын ЕБС захирал
6.	Р.Өлзийхишиг	Хан-уул дүүргийн 34-р дунд сургууль захирал
7.	Н.Батбаяр	БГД, Ган зам 20-р сургууль захирал
8.	Л.Уянга	Сэлэнгэ аймгийн 3-р сургууль захирал
9.	Ч.Эрдэнэбилэг	Дархан-уул аймгийн 12-р сургууль захирал
10.	П.Хувьзаяа	93-р сургуулын захирал
11.	Ц.Бат-Эрдэнэ	Төв аймаг Алтан булаг сумын ЕБС-ийн захирал
12.	Бат-Ундар	Q-Art галерей захирал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1.	Ж.Эрдэнэдэлгэр	2016	Олонлог сургуулийн багш
2.	О.Баасандагва	2015	Орчлон сургуульд багш
3.	Б.Аюурзана	2019	84-р сургуульд дизайн зурагзүйн багш
4.	М.Лувсандагва	2019	84-р сургуульд дизайн зурагзүйн багш
5.	Б.Буянзаяа	2019	114-р сургуулийн дизайн зурагзүйн багш
6.	Д.Баясал	2019	Тольт сургуульд багш
7.	Ц.Галбадрах	2017	Шинэ Монгол сургууль
8.	Э.Гүнжидмаа	2015	15-р сургуулийн багш
9.	Б.Батзориг	2018	24-р сургуулийн багш
10.	Ө.Должинсүрэн	2017	Сургалтын төвийн багш
11.	Э.Лхагвасүрэн	2019	ӨЗБЛАС, багш

12.	Г.Бямба-Эрдэнэ	2019	МУБИС, Лицей, багш
13.	Ж.Серикболат	2015	Монгень, багш
14.	С.Пүрэвдорж	2018	ӨЗБЛАС, багш
15.	Ц.Уранбилэг	2015	Говь кашмер

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/